



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/115/СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Сайншанд 2020 он	Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг Утас: 70523020 Цахим хаяг: enhtsetsege@audit.gov.mn Аудитор: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
Аудитын тайлан .....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
Менежментийн захидал .....	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	12
1.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
1.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
1.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	20
1.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	21
1.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	23



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2020.02.20. № 1-6/96  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗРЫН ДАРГА Г.ЭНХЦЭЦЭГ  
ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

010020030

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## 2.1. Оршил

Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Г.Энхцэцэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дүгээр сарын 11-ээс 2020 оны 02 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор У. Оюунтүлхүүр хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 107 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь хүн амын хэрэгцээнд нийцсэн чанартай, аюулгүй, хүртээмжтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэвтрүүлэхэд оршино.

Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргын гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах
- Улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттайгаас бусад эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргаж, тухайн шатны Засаг даргад танилцуулах
- Эмнэлгийн орыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хязгаарт багтаан зохицуулах
- Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих
- Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- УИХ-ын 2019.02.01-ний 21-р тогтоол
- ЗГ-ын 2018.12.19-ний 382-р тогтоол

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Эрүүл мэндийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд асoлуoс программ хангамж ашигладаг байна.

Эрүүл мэндийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Эрүүл мэндийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн Цэвэр хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,028,959.3 мянган төгрөгөөс тооцон 10,289.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 10,289.6 мянган төгрөгөөр тооцсон нь суурийг төлөвлөлтийн үеийн сууриар сонгосонтой холбоотой болно. /шалтгааныг бичих/

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрүүл мэндийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 126,359.02 мянган төгрөгөөр буюу 13.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	7,873.6	0.0	-7,873.6
Урьдчилгаа	732.6	0.0	-732.6
Бараа материал	36,361.9	120,918.5	84,556.6
Үндсэн хөрөнгө	857,632.2	908,040.7	50,408.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>902,600.3</b>	<b>1,028,959.3</b>	<b>126,359.0</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	902,600.3	1,028,959.3	126,359.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>902,600.3</b>	<b>1,028,959.3</b>	<b>126,359.0</b>

Авлага дансны үлдэгдэл буурсан нь хувь хүний авлага, халаалт, цэвэр бохир ус, татварын авлага байсныг барагдуулснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн 7,873.6 мянган төгрөгийн авлагаас 295.1 мянган төгрөгийн авлага нь хувь хүнээс авах авлага байсан байна. Эдгээр нь бүгд барагдсан болно.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь үнэ төлбөргүй ирдэг вакциныг бүртгэлд тусгасан, сургалтуудын самбар, тараах материалын үлдэгдэл, гамшгийн нөөц зэргээс шалтгаалжээ. Үнэ төлбөргүй ирдэг вакцинууд нь өрх, сумдын ЭМТ-үүд, нэгдсэн эмнэлэгт сар бүр хуваарилагддаг товлолын болон тархварын зориулалтын вакцинуудаас бүрддэг. Энэ нь 3 сарын нөөцтэй байдаг. Бараа материалын дансны түлш шатах тослох материалын үлдэгдэлд 2,050.0 мянган төгрөгийн 2018 онд худалдаж авсан шатахууны талон ашиглагдаагүй байна. Энэ нь Монгол Улсын Ерөнхий сайдын 105 дугаар захирамжийн дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын 4-р багийн 15-с дээш насны хүн амыг сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг 2018 оны 07 дугаар сарын 21-ээс 07 сарын 26-ыг дуустал зохион байгуулсан ажлын зарцуулагдаагүй үлдсэн шатахууны талон бөгөөд зарцуулах чиглэл өгнө гэсэн тул хүлээгдэж байгаа нь шатах тослох материалын үлдэгдэлд бүртгэлтэй байна.

Мөн Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8.1, 8.2, 10.3.5, 24.1, 51.1, 51.2 дугаар зүйлд заасны дагуу гамшгаас хамгаалах мэргэжлийн анги гэсэн статустай оролцдогоороо тухайн жилийн төсвийн 1%-тай тэнцэхүйц /11,532.5 мянган төгрөг/ хэмжээгээр нөөц бүрдүүлдэг тул хөдөлмөр хамгааллын хэрэгсэл – 6,430.0 мянган төгрөг, эм бэлдмэл – 1,270.3 мянган төгрөг, шатахуун – 3,800.0 мянган төгрөг нийт 11,500.3 мянган төгрөгийн нөөц бүрдүүлсэн. Энэхүү нөөцөөс сумдын ЭМТ-үүд, аймгийн болон Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлгүүдэд хуваарилдаг байна. Мөн оны эцэст газрын даргын тушаал гарч зохион байгуулсан сургалтуудын плакат, хөлтэй самбар, хөлтэй баннер, СиДи, үзүүлэнгийн самбар, тараах материал зэрэг 5,585.0 мянган төгрөгийн үнэ бүхий материалууд бичиг хэргийн материалын дансны үлдэгдэлд байгаа юм. Аж ахуйн материалын өсөлт нь гамшгийн бэлэн байдлыг хангах хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийн нөөц бүрдүүлсэнтэй шууд холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь ЭМЯ-аас автомашин хуваарилсан, машин тоног төхөөрөмж, тавилга худалдан авснаас шалтгаалжээ. ЭМ-ийн сайдын 2019.02.13-ний өдрийн А/69 тоот тушаалаар 84,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий Ниссан Патрол маркийн жийп автомашиныг үнэ төлбөргүй хуваарилсан, мөн батлагдсан төсвийн хүрээнд ЭМГ-ын даргын 2019.12.30-ны өдрийн А/175 тоот тушаалаар машин тоног төхөөрөмжид 4,321.1 мянган төгрөг, тавилга эд хогшилд 6,360.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.

Үндсэн хөрөнгө аймгийн засаг даргын 2019.05.02-ны өдрийн А/381 тоот захирамжаар 21,835.0 мянган төгрөгийн үнэ бүхий KZ-6460 маркийн автомашиныг худалдан борлуулж, аймгийн ИТХ-ын даргын 2019.11.15-ний өдрийн 74 тоот тогтоолоор акталсан 500.7 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус хасагдсан байна.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт байхгүй.

Өр төлбөр данс үлдэгдэл байхгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,028,959.3 мянган төгрөг болж 126,359.0 мянган төгрөгөөр өссөн нь 256,759.8 мянган төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн бараа материалын орлогоос шалтгаалжээ. Энэ нь ХӨСҮТ-ээс товлолын болон тархварын вакцинууд, Глобал сангаас бэлгийн замын халдварт өвчний үеийн эм бэлдмэлээс бүрдэж байна

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эрүүл мэндийн газар нь өөрийн орлого байхгүй бөгөөд 100% улсын төсвөөс санхүүждэг.

Хүснэгт 2. Санхүүжилт

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын төсвийн санхүүжилт	1,153,249.5	1,153,249.5	-	100.0
Нийт дүн	<b>1,153,249.5</b>	<b>1,153,249.5</b>	-	<b>100.0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг харуулав.

### Зардлын хэмнэлт, хэтрэлтийн тайлбар

№	Эдийн засгийн ангилал	Хэмнэлт/хэтрэлт	Тайлбар
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	6,741,782.65	Шаардлагатай орон тоо дутуу байсан учир хэмнэгдсэн
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэл	2,691,308.48	Шаардлагатай орон тоо дутуу байсан учир хэмнэгдсэн
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,692,247.68	Хэмнэгдсэн
4	Томилолт, зочны зардал	5,200.0	хэмнэгдсэн
5	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	2,053,626.87	Интернэтийн үйлчилгээгээ хямд үнэтэй оператор компаниар сольсон
6	Бусад урсгал шилжүүлэг	12,431,031.0	2 хүний ажилласан жилээс ТЗ-ын эмнэлэгт ажилласан жил нь хасагдсан учраас тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж хэмнэгдсэн
	Нийт	28,615,938.68	

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,124,633.6 мянган төгрөг буюу 97.5 хувьтай байгаа нь цалингийн сангийн хэмнэлт, үүнтэй уялдан ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл, тогтмол зардлын хэмнэлт, мэдээлэл технологийн зардал, урсгал шилжүүлгийн хэмнэлттэй холбоотой байна. Жилийн эцэст 28,615.9 мянган төгрөг төвлөрүүлсэн.

**Нэмэлт төсөв:** Засаг даргын нөөц хөрөнгөөс 12,977.1 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 114,789.8 мянга, нийт 127,766.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 2,414.0 мянга, томилолтод 10,984.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 113,888.9 мянга, нэр данс зөрүү 480.0 мянга нийт 127,766.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 9 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

#### 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 5,247.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 4,511.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 735.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 735.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

#### 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Нэмэлтээр орсон шатахууны зардлыг бараа материалын бүртгэлд авалгүй шууд зардалд бүртгэсэн байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Эрүүл мэндийн газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 140 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 7.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос бүрэн барагдуулж дууссан.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Эрүүл мэндийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. Зардлын данстай холбоотой асуудал*

*1.1. Илрүүлэлт: Ажил олгогчоос төлөх 735.9 мянган төгрөгийн НДШ-ийн зардлыг цалингийн зардлаас төлсөн*

*1.2. Эрсдэл: Батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулах*

*1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55-р тушаалын дагуу зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах” тухай хууль журмыг баримталж ажиллах*

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>44,968,092.89</u></b>	<b><u>120,536,555.13</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	7,873,622.05	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	295,101.05	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	7,578,521.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	7,578,521.00	00.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	732,570.00	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	732,570.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	36,361,900.84	120,536,555.13
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	4,180,443.90	68,025,583.42
35110	Тусгай зориулалттай материал	00.00	64,627,589.52
35130	Эм боох материал	4,180,443.90	3,397,993.90
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	32,181,456.94	52,510,971.71
35410	Бичиг хэргийн материал	3,321,026.00	10,744,900.00
35420	Аж ахуйн материал	23,136,124.44	33,808,695.44
35430	Сэлбэг хэрэгсэл	60,000.00	60,000.00
35440	Түлш, шатах тослох материал	4,799,416.50	6,527,006.27
35450	Барилгын засварын материал	864,890.00	1,370,370.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>857,632,174.23</u></b>	<b><u>908,040,737.55</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	857,632,174.23	908,040,737.55
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	832,288,174.23	882,696,737.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	760,924,793.58	760,924,793.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-15,424,713.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	78,306,297.00	140,471,297.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-78,306,297.00	-62,771,297.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	132,492,555.89	136,487,345.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	-79,413,865.43	-97,652,161.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,742,364.99	50,928,342.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,872,341.26	-30,675,036.67
39214	Бусад үндсэн хөрөнгө	690,300.00	690,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-660,133.54	-666,633.58
39217	Ном	384,500.00	384,500.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	25,344,000.00	25,344,000.00
39301	Програм хангамж	785,000.00	785,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-785,000.00	-785,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	25,344,000.00	25,344,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>902,600,267.12</u></b>	<b><u>1,028,577,292.68</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>902,600,267.12</u></b>	<b><u>1,028,577,292.68</u></b>

<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	902,600,267.12	1,028,577,292.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	831,604,364.82	831,604,364.82
51101	Өмч: - төрийн	831,604,364.82	831,604,364.82
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-104,495,862.00	21,481,163.56
51210	Өмнөх үеийн үр дүн	-104,495,862.00	-104,495,862.00
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	125,977,025.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	175,491,764.30	175,491,764.30
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>902,600,267.12</u></b>	<b><u>1,028,577,292.68</u></b>

## 1.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,336,191,364.95</b>	<b>1,621,296,213.84</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>15,501,591.40</b>	<b>340,759,803.84</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	11,574,591.40	256,759,803.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,574,591.40	256,759,803.84
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64,550.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,510,041.40	256,759,803.84
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>3,927,000.00</b>	<b>84,000,000.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	3,927,000.00	84,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,320,689,773.55</b>	<b>1,280,536,410.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,169,572,100.00</b>	<b>1,153,249,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,169,572,100.00	1,153,249,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>151,117,673.55</b>	<b>127,286,910.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	93,395,315.55	14,613,470.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,068,100.00	12,977,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,636,258.00	33,947,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,018,000.00	65,748,940.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,340,366,997.52</b>	<b>1,495,319,188.28</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,340,366,997.52</b>	<b>1,495,319,188.28</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>586,654,914.36</b>	<b>842,809,871.60</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>268,353,842.95</b>	<b>339,974,036.10</b>
210101	Үндсэн цалин	173,679,605.95	264,533,140.95
210102	Нэмэгдэл	67,524,255.00	33,605,032.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,638,000.00	27,607,344.00
210104	Урамшуулал	10,511,982.00	14,228,518.80
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>31,907,570.89</b>	<b>42,385,157.82</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,255,465.35	30,281,669.72
210202	Тэтгэмжийн даатгал	2,326,591.72	3,876,082.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,464,716.01	2,775,573.00
210204	Ажилгүйдлийн даатгал	532,547.33	681,091.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,328,250.48	4,770,742.05

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	33,470,228.00	45,143,889.32
210301	Гэрэл, цахилгаан	4,433,917.00	4,977,056.32
210302	Түлш, халаалт	25,098,161.00	25,688,441.00
210303	Цэвэр, бохир ус	3,938,150.00	14,478,392.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	31,755,759.50	20,880,426.23
210401	Бичиг хэрэг	10,963,750.00	3,509,990.00
210402	Тээвэр, шатахуун	14,459,807.00	13,128,654.23
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,085,621.50	1,391,885.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	364,749.00	926,498.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,881,832.00	1,500,849.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	422,550.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	13,308,394.60	195,714,664.32
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,308,394.60	195,714,664.32
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,222,820.00	2,368,378.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	90,000.00
210604	Урсгал засвар	8,222,820.00	2,278,378.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	6,714,800.00	18,514,800.00
210702	Дотоод албан томилот	6,714,800.00	18,514,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	145,703,366.00	116,051,621.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	138,824,689.00	105,434,178.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,024,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	999,105.00	983,584.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	160,000.00	145,033.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	37,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,964,900.00	8,395,026.13
210807	Газрын төлбөр	12,672.00	32,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	47,218,132.42	61,776,898.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,997,129.20	13,366,487.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,836,300.00	4,137,475.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,384,703.22	44,272,936.68
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	753,712,083.16	652,509,316.68
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	735,746,740.00	623,893,369.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	217,575,822.00	334,841,707.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	518,170,918.00	288,451,662.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	600,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	17,965,343.16	09.00

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,965,343.16	09.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	28,615,938.68
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	28,615,938.68
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>-4,175,632.57</u></b>	<b><u>125,977,025.56</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	4,793,209.77	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,793,209.77	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-4,793,209.77	00.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>-8,968,842.34</u></b>	<b><u>125,977,025.56</u></b>

### 1.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,320,754,323.55</u></b>	<b><u>1,280,536,410.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>64,550.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	64,550.00	00.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	64,550.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64,550.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,320,689,773.55</b>	<b>1,280,536,410.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,169,572,100.00	1,153,249,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,169,572,100.00	1,153,249,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	151,117,673.55	127,286,910.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	93,395,315.55	14,613,470.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,068,100.00	12,977,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,636,258.00	33,947,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,018,000.00	65,748,940.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,306,619,745.15</u></b>	<b><u>1,269,854,910.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,306,619,745.15</b>	<b>1,269,854,910.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>552,907,661.99</b>	<b>617,345,593.32</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	267,544,070.00	338,347,752.35
210101	Үндсэн цалин	185,727,704.00	243,321,700.00
210102	Нэмэгдэл	54,666,384.00	45,561,510.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,638,000.00	26,080,000.00
210104	Урамшуулал	10,511,982.00	23,384,542.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,018,547.89	40,882,171.52
210201	Тэтгэврийн даатгал	31,217,078.16	28,787,629.47
210202	Тэтгэмжийн даатгал	200,367.43	3,661,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	160,293.95	2,929,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	40,073.48	732,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	400,734.87	4,770,742.05

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,001,517.00	40,399,537.32
210301	Гэрэл, цахилгаан	4,433,917.00	4,977,056.32
210302	Түлш, халаалт	21,050,000.00	25,590,936.00
210303	Цэвэр, бохир ус	10,517,600.00	9,831,545.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,608,389.50	24,256,800.00
210401	Бичиг хэрэг	4,261,250.00	4,413,600.00
210402	Тээвэр, шатахуун	12,000,000.00	14,856,244.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,368,821.50	1,399,585.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	1,249,990.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,978,318.00	2,337,381.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,447,650.00	3,300,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,679,650.00	2,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,768,000.00	800,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	11,023,691.60	10,252,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,009,671.60	44,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,514,710.00	6,708,600.00
210604	Урсгал засвар	8,499,310.00	3,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,714,800.00	18,478,800.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	6,714,800.00	18,478,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	158,139,318.00	123,975,874.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	147,725,541.00	113,731,001.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,024,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	999,105.00	983,584.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	160,000.00	145,033.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	37,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,500,000.00	8,022,456.13
210807	Газрын төлбөр	12,672.00	32,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	16,409,678.00	17,452,058.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,247,527.00	13,259,473.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,162,151.00	4,192,585.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>753,712,083.16</b>	<b>652,509,316.68</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	735,746,740.00	623,893,369.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	217,575,822.00	334,841,707.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	518,170,918.00	288,451,662.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	17,965,343.16	09.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,965,343.16	09.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	28,615,938.68

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	28,615,938.68
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>14,134,578.40</u></b>	<b><u>10,681,500.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>14,134,578.40</b>	<b>10,681,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>14,134,578.40</b>	<b>10,681,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	14,134,578.40	10,681,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,134,578.40	10,681,500.00
<b>2260</b>	<b>Гадаад эх үүсвэрээр</b>	00.00	00.00
226001	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-14,134,578.40</u></b>	<b><u>-10,681,500.00</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

#### 1.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	831,604,364.82	1,937,989.00	-73,606,661.65	759,935,692.17
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>831,604,364.82</b>	<b>1,937,989.00</b>	<b>-73,606,661.65</b>	759,935,692.17
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-23,858,347.01	-23,858,347.01
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>831,604,364.82</b>	<b>175,491,764.30</b>	<b>-104,495,862.00</b>	<b>902,600,267.12</b>
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>831,604,364.82</b>	<b>175,491,764.30</b>	<b>-104,495,862.00</b>	<b>902,600,267.12</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>831,604,364.82</b>	<b>175,491,764.30</b>	<b>-104,495,862.00</b>	<b>902,600,267.12</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	125,977,025.56	125,977,025.56
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>831,604,364.82</b>	<b>175,491,764.30</b>	<b>21,481,163.56</b>	<b>1,028,577,292.68</b>

### 1.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,153,249,500.00	1,124,633,561.32	28,615,938.68	97.52
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,153,249,500.00	1,124,633,561.32	28,615,938.68	97.52
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	516,925,100.00	500,740,192.32	16,184,907.68	96.87
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	345,089,700.00	338,347,752.35	6,741,947.65	98.05
210101	Үндсэн цалин	243,321,700.00	243,321,700.00	0.00	100.00
210102	Нэмэгдэл	46,610,000.00	45,561,510.35	1,048,489.65	97.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,600,000.00	26,080,000.00	4,520,000.00	85.23
210104	Урамшуулал	24,558,000.00	23,384,542.00	1,173,458.00	95.22
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	43,573,300.00	40,882,171.52	2,691,128.48	93.82
210201	Тэтгэврийн даатгал	28,926,056.00	28,787,629.47	138,426.53	99.52
210202	Тэтгэмжийн даатгал	3,661,836.00	3,661,900.00	-64.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,929,109.00	2,929,500.00	-391.00	100.01
210204	Ажилгүйдлийн даатгал	732,727.00	732,400.00	327.00	99.96
210205	Эрүүл мэндийн даатгал	7,323,572.00	4,770,742.05	2,552,829.95	65.14
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	45,091,800.00	40,399,537.32	4,692,262.68	89.59
210301	Гэрэл, цахилгаан	5,564,900.00	4,977,056.32	587,843.68	89.44
210302	Түлш, халаалт	25,688,500.00	25,590,936.00	97,564.00	99.62
210303	Цэвэр, бохир ус	13,838,400.00	9,831,545.00	4,006,855.00	71.05
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,910,400.00	22,910,400.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	4,263,600.00	4,263,600.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	13,215,700.00	12,933,844.00	281,856.00	97.87
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,367,500.00	1,399,585.00	-32,085.00	102.35
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	1,249,990.00	-249,990.00	125.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,063,600.00	3,063,381.00	219.00	99.99
2105	<b>Нормативт зардал</b>	3,300,000.00	3,300,000.00	0.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00	0.00	100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	19,708,600.00	19,708,600.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	4,504,610.00	-4,610.00	100.10

210602	Тавилга	5,000,000.00	4,995,390.00	4,610.00	99.91
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,708,600.00	6,708,600.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	3,500,000.00	3,500,000.00	0.00	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,500,000.00</b>	<b>7,494,800.00</b>	<b>5,200.00</b>	<b>99.93</b>
210702	Дотоод албан томилолт	7,500,000.00	7,494,800.00	5,200.00	99.93
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,298,500.00</b>	<b>10,244,873.13</b>	<b>2,053,626.87</b>	<b>83.30</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	1,024,000.00	176,000.00	85.33
210803	Даатгалын үйлчилгээ	983,600.00	983,584.00	16.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	145,100.00	145,033.00	67.00	99.95
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	37,800.00	37,800.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,900,000.00	8,022,456.13	1,877,543.87	81.03
210807	Газрын төлбөр	32,000.00	32,000.00	0.00	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>17452800.00</b>	<b>17452058.00</b>	<b>742.00</b>	<b>100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,260,200.00	13,259,473.00	727.00	99.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,192,600.00	4,192,585.00	15.00	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>636,324,400.00</b>	<b>623,893,369.00</b>	<b>12,431,031.00</b>	<b>98.05</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>636,324,400.00</b>	<b>623,893,369.00</b>	<b>12,431,031.00</b>	<b>98.05</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	343,684,600.00	334,841,707.00	8,842,893.00	97.43
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	292,039,800.00	288,451,662.00	3,588,138.00	98.77
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	600,000.00	0.00	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,153,249,500.00</b>	<b>1,124,633,561.32</b>	<b>28,615,938.68</b>	<b>97.52</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,153,249,500.00</b>	<b>1,124,633,561.32</b>	<b>28,615,938.68</b>	<b>97.52</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,153,249,500.00	1,124,633,561.32	28,615,938.68	97.52
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>30.00</b>	<b>30.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	24.00	24.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	0.00	100.00

### 1.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>127,286,901.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>127,286,901.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	127,286,901.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,072,400.00
210401	Бичиг хэрэг	150,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,922,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	10,984,000.00
210702	Дотоод албан томилолт	10,984,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	114,230,501.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	114,230,501.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	127286901.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	127,286,901.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	14,613,470.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,977,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,947,391.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	65,748,940.00
131106	Төсвийн урамшуулал	00.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	